

	1-р зорилтын хүрээнд:	5400 ингэ төллөж, төл бойжилт 99.6 хувь буюу 5381 ботго бойжиж байна.
	2-р зорилтын хүрээнд:	Хугацаа болоогүй
	3-р зорилтын хүрээнд:	МАНЭШХүрээлэнгийн эрдэмдэт, тэмээ судлаач доктор Б.Бичээ нараар Хулд сумын малчдад тэмээ маллах арга ухаан, ашиг шимийг нэмэгдүүлэх, үржил селекцийн ажлыг чиглэлтэй явуулах талаар сургалт зөвлөгөөг өгүүлсэн. Мөн 11 сарын дундуур аймгийн тэмээний баяр арга хэмжээг зохион байгуулж тэмээчдийн арга туршлага, цаашид анхаарах асуудлын талаар бага хурал зохион байгуулахаар төлөвлөөд ажиллаж байна.
	4-р зорилтын хүрээнд:	Хулд сумын “Олдохын хүрэн бор” тэмээнд явуулах судалгааны ажлын арга зүйг МАНЭШХүрээлэнгийн 2018 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн их эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж батлуулаад хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Судалгааны арга зүйн дагуу Олдохын хүрэн бор тэмээнд явуулах судалгаа болоод шаардагдах дээж материалыг авч МАНЭШХүрээлэнд хүлээлгэн өгсөн. Судалгааны ажлыг МАНЭШХүрээлэнгийн эрдэмтэд болон ахмад мал зүйч доктор Б.Бичээ нартай хамтран зохион байгуулж үр дүнтэй хэрэгжүүлсэн.
	5-р зорилтын хүрээнд:	3 сард зохион байгуулах байсан боловч малын гоц халдварт өвчний улмаас хойшлуулж 11 сард зохион байгуулахаар болсон. /Хугацаа болоогүй/
	6-р зорилтын хүрээнд:	Аймгийн хэмжээнд нийт 8 суманд 12000 тэмээг шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтанд хамруулсан.
	7-р зорилтын хүрээнд:	“Олдохын хүрэн бор” тэмээнд явуулах судалгааны ажлын арга зүйг МАНЭШХүрээлэнгийн их эрдмийн зөвлөлийн 2018 оны 03 сарын 02-ний өдрийн их эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж батлуулсан.
	8-р зорилтын хүрээнд:	Хулд сумын 2000 тэмээнд МАНЭШХүрээлэнгийн эрдэмтийн баг, ахмад Мал зүйч доктор Б.Бичээ нартай хамтарсан мэргэжилтний баг үзлэг ангилалтыг өгч үнэлэлт дүгнэлт өгсөн. Үзлэг ангилалтаар бусад үүлдэр омгийн малаас ялгагдах шинж төрхтэй болох нь гене болоод фенотип шинжээрээ батлагдсан.
	9-р зорилтын хүрээнд:	Хугацаа болоогүй
7	Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)	Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлсэнээр нутгийн эрс тэс уур амьсгалд дасан зохицсон ашиг шим өндөртний мал сүргийг хайрлан хамгаалах болон өсгөн үржүүлэх, судалгааны шинжилгээний ажлыг явуулах, орон нутгийн сайжруулагч болоод өөр аймгуудад сайжруулагчаар ашиглах, цаашлаад нутгийн брэнд малтай болох боломж бүрдэж байгаа юм.
8	Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ.	Захиалагч талууд, хэрэгжүүлэгч талууд, санхүүжүүлэгч тал, гүйцэтгэгч талууд хэрхэн хамтарч ажилласан талаар энд бичнэ.

9	Хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (өөрийн үнэлгээ)	Биелэлт дундаж	Зорилтын тоо	1	2	3	4	5	6	7	8	9	
		88.3 %	9	90	-	40	100	-	100	100	100	-	
10	Хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ (ЗГХЭГазрын үнэлгээ)	нэгдсэн	Нэгдсэн үнэлгээ										
			%										

Хөтөлбөрийн биелэлт гаргасан: Мэргэжилтэн:.....Ж.Батбилэг

Хянасан: Ахлах мэргэжилтэн:.....О.Ганцэцэг